Тамхинаас гаргах эмчилгээ, зан үйлийг өөрчлөх интервенцийн үр дүнг үнэлэх нь

Д.Мөнх-Учрал[1*], Прамиль Сийнгх[2], Еркебулан[1], Г.Надмидцэрэн[1], Ч.Аззаяа[1], Ц.Мөнхнасан[1], Д.Алтанчимэг[3], М.Сугармаа[1], С.Хандмаа[6], Т.Ганцэцэг[7], Д.Даваалхам[1]

[1]АШУҮИС, Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль, [2]Лома Линда Их Сургууль, Хавдарын Төв, АНУ

[3]АШУҮИС, Нийгэм Зан Үйл, Эрүүл Мэндийн Төв

[6]АШУҮИС, Төгсөлтийн Өмнөх Сургалтын Бодлого Зохицуулалтын Газар

[7]АШУҮИС, Анагаах Ухааны Сургууль

Цахим шуудан: Munkhuchral.d@mnums.edu.mn, Утас: 99002562

Түлхүүр үг:

Тамхи, никотины хамаарлын түвшин, цитизин, никотин орлуулах наалт, зан үйлийг өөрчлөх зөвлөгөө

ҮНДЭСЛЭЛ

Дэлхий дахинд 2022 оны байдлаар 1.3 тэрбум хүн буюу насанд хүрсэн 5 хүн тутмын 1 нь буюу нийт хүн амын 22.3 хувь нь тамхи татаж байна. Жил бүр тамхины шалтгаант нас баралт 8 сая бүртгэгдэж байна. Үүнээс 7 сая гаруй тамхи татдаг, 1.2 сая орчим нь дам тамхидалтад өртөж буй иргэд байна.[2] 2020 оны байдлаар Монгол улсад тамхины шалтгаант нас баралт 100.000 хүн амд 166.6 тохиолдож, Дэлхийн нийт 195 улсаас өвчлөл, нас баралтын тохиолдол өндөр эхний 10 багтаж байна.[3] Монгол улсын хэмжээнд нийт хүн амын 27.1 хувь нь буюу 2 эрэгтэй тутмын 1, харин эмэгтэйчүүдийн хувьд 20 эмэгтэй тутмын 1 нь тамхи татаж байна.[4] Тамхи татдаг иргэдийн гурван иргэн тутмын хоёр нь тамхинаас гарах хүсэлтэй байдаг ч ойролцоогоор 50 хувь нь тамхинаас гарах оролдлого хийж үзсэн байдаг ажээ.[2] Харамсалтай нь тамхинаас гарах оролдлого хийсэн арван хүн тутмын нэг нь тамхинаас амжилттай гарч чаддаг байна.[2]

Судалгааны зорилго

Тамхинаас гаргах цитизин (табекс) эм, никотин орлуулах наалт эмчилгээний үр дүнг тооцож, зан үйлийг өөрчлөх зөвлөгөөний үзүүлэх нөлөөг судлах.

Судалгааны зорилт

- Тамхинаас гаргах цитизин (табекс) эм, никотин орлуулах наалт эмчилгээний үр дүнг тооцох
- Тамхинаас гаргах гаргах эмчилгээний үр дүнд зан үйлийг өөрчлөх зөвлөгөөний үзүүлэх нөлөөг судлах

Судалгааны материал ба аргазүй

Судалгааны загвар: Эмнэлэгт суурилсан, дан нууцлалтай эмнэлзүйн туршилт судалгааны загварыг ашигласан.

Судалгааны хамрах хүрээ, түүвэрлэлт

Судалгаа 2022 оны 2 сарын 1-ээс 2022 оны 7 сарын 1-ний хооронд үргэлжилсэн. Эмчилгээний нэг бүлэгт 350 хүн буюу нийт 700 хүн оролцсон.

Хүснэгт 1. Судалгааны түүвэр (Дүүргээр)

Дүүрэг	Нийт хүн ам (18-65 хүртэлх настай)	Суурь үнэлгээ	Эмчилгээ эхлүүлсэн	Бүрэн дууссан
Баянзүрх	230,125	269	197	162
Сонгинохайрхан	202,652	216	173	125
Баянгол	130,160	226	140	102
Хан-Уул	121,296	221	144	133
Чингэлтэй	85,313	167	116	98
Сүхбаатар	86,353	151	105	80
Нийт	**855,899**	**1250**	**875**	**700**

Судалгаанд хамруулах шалгуур

- Тамхинаас гарах хүсэлтэй (Өдөрт 5–иас доошгүй тамхи татдаг)
- 18 – 65 хүртэлх насны Монгол улсын иргэн
- Тухайн дүүргийн үндсэн харьяалалтай эсхүл бүртгэлтэй түр оршин суугч
- Эрүүл мэндийн даатгал төлдөг байх

Судалгаанаас хасах шалгуур

Судалгаанаас жирэмсэн болон хөхүүл, тамхинаас гаргах бусад төрлийн эмчилгээнд хамрагдаж байгаа, дараах өвчний оношь тавигдсан тохиолдолд судалгаанаас хассан.

- Зүрхний цус хомстох өвчин, зүрхний дутагдал, даралт ихсэлт, тархины судасны эмгэгүүд, цусны судасны бөглөрөлт өвчин
- Бамбай булчирхайн гормоны ялгаралт ихсэх, чихрийн шижин, элэг, бөөрний дутагдал, бөөрний булчирхайн хромаффин эсийн хавдар
- Ходоод, улаан хоолойн сөргөө өвчин, ходоод гэдэсний идэгдмэл шархлаа өвчин, арьс харшлын гаралтай суурь өвчтэй, сэтгэцийн эмгэгүүд зэрэг болно.

Эмнэлзүйн туршилт судалгааны үе шат

Тамхинаас гарах шийдвэр гаргасан иргэд Улаанбаатарын хотын 6 дүүргийн ЭМТ-ийн Сэтгэц, донтолтын кабинетын эмчийн үзлэгт хамрагдаж тэнцсэн тохиолдолд ЭМНА зөвлөгөөний бүлэгт санамсаргүй (1:1) хуваарилна. Зөвлөгөөтэй бүлэгт оролцогчдод ЭМНА зан үйлийг өөрчлөх (5А, 5R аргачлал) зөвлөгөө өгч, тамхинаас гаргах 25-28 хоногийн курс эмчилгээний эм эсвэл никотин орлуулах наалт эмчилгээ , зан үйлийг өөрчлөх зөвлөгөөг үнэ төлбөргүй өгсөн.

Эмийн эмчилгээний бүлэг: Оролцогчдод 25 өдөр хэрэглэх, нэг курс эмчилгээний цитизин (табекс) эмийг олгосон. Цитизинийг (табекс) эмчилгээний 1-3 дахь хоногт өдөрт 1.5 мг/6, 4-12 дахь хоногт өдөрт 1.5 мг/5, 13-16 дахь хоногт өдөрт 1.5 мг/4, 17-20 дахь хоногт өдөрт 1.5 мг/3, 21-25 дахь хоногт өдөрт 1.5 мг/2 ширхэг уух тунгаар хэрэглэсэн.

Никотин орлуулах наалт эмчилгээний бүлэг: Оролцогчдод 28 өдөр хэрэглэх, нэг курс эмчилгээний арьсны наалтыг олгосон. Никотин орлуулах наалт эмчилгээний тунг өдөрт 19-өөс их тамхи татдаг бол 0-14 дахь хоногт 28 мг, 15-28 дахь хоногт 10 мг тунгаар, өдөрт 20-иос олон их тамхи татдаг бол 0-7 хоногт 42 мг, 8-14 дахь хоногт 28 мг, 15-28 дахь хоног 10 мг тунгаар хэрэглэсэн.

Зан үйлийг өөрчлөх зөвлөгөөний (5А, 5R) аргачлал: 2014 онд ДЭМБ-аас боловсруулсан 5А, 5R аргачлалын удирдамжийн дагуу зан үйлийг өөрчлөх зөвлөгөөг өгсөн. **1. Ask-асуух** үе шатанд оролцогчдын тамхины хэрэглээг үнэлж, өдөрт 5 ≥ дээш тамхи татдаг тохиолдолд судалгаанд оролцуулсан. **2. Advise-зөвлөх** үе шатанд тамхи хүний эрүүл мэнд, эдийн засаг, нийгмийн амьдралд үзүүлэх хор уршгийн талаар суурь зөвлөгөө өгсөн. **3. Assess-үнэлэх** үе шатанд тамхинаас гарах бэлэн байдлыг үнэлсэн. Хэрэв оролцогч тамхинаас гарахад бэлэн биш байгаа тохиолдолд 5R аргачлалын дагуу нэмэлт зөвлөгөө өгч бэлэн байдлын үнэлгээг дахин хийсэн. **4. Assist-туслах** үе шатанд оролцогч бэлэн байгаа тохиолдолд эмчилгээг эхлүүлж зөвхөн зөвлөгөөтэй бүлэгт оролцогчдод ЭМНА зан үйлийг өөрчлөх зөвлөгөө (5А, 5R) өгсөн. **5. Arrange-зохицуулах** үе шатанд тамхины хэрэглээг өөрийн үнэлгээнд тулгуурлаж үнэлсэн.[4]

Мэдээллийг 23107 иргэнд хүргэснээс 1611 хүн тамхинаас гаргах эмчилгээг сонирхож ирсэн. Үүнээс судалгааны үндсэн шалгуур хангасан 1250 хүнд суурь зөвлөгөө өгч 958 (76.6%) хүн тамхинаас гарах шийдвэр гаргасан. Үүнээс 83 хүн эмчийн дүгнэлтээр (эсрэг заалт) судалгаанаас хасагдаж 875 хүн судалгааг эхлүүлсэн. Эмчилгээний 14 дахь хоног хяналтын 1 болон 2 дахь саруудад тамхины хэрэглээг үнэлж үр дүнг тооцсон.


Судалгааны хэрэглэгдэхүүн

Тамхинаас гаргах цитизин (Табекс) эмийн эмчилгээ, никотин орлуулах наалт эмчилгээний үр дүнг тооцож, зан үйлийг өөрчлөх интервенцийн үзүүлэх нөлөөг судлахын тулд 6 бүлэг 60 асуулттай асуумж ашигласан.

- Тамхины хэрэглээ
- Никотины хамаарлын фагерстром үнэлгээний асуумж (FTND)
- Цитизин (Табекс) эм, никотин орлуулах наалтын хэрэглээ
- Табекс, никотин орлуулах наалт эмчилгээний гаж нөлөө
- Архины хэрэглээг үнэлэх AUDIT асуумж
- Тамхинаас гарах бэлэн байдлын үнэлгээ

Ёс зүйн асуудал

2021 оны 11 сарын 19-нд АШУҮИС, Судалгааны ёс зүйн хяналтын хорооны хурлаар (2021/3-12) судалгааны ёс зүйн зөвшөөрөл, 2013 оны 01 сарын 20-ний хурлар (2023/д-01) ёс зүйн дүгнэлт авсан.



Зураг 1. *Эмнэлзүйн туршилт судалгааны хуваарилалт*

Статистик боловсруулалт

P утга 0.05-аас бага байх тохиолдолд ялгааг статистик үнэн магадлалтай гэж үзнэ. Хувиар илэрхийлэгдсэн хувьсагчдад Пирсоны хи квадратын арга (Pearson’s Chi-square test), Фишер эксакт тестийн (Fisher exact test) аргуудыг ашигласан. Хэрэв p утга 0.05-аас бага байх тохиолдолд ялгааг статистик үнэн магадлалтай гэж үзсэн.

Судалгааны үр дүн

Тамхинаас гаргах эмчилгээнд 18-65 хүртэлх насны нийт 875 (100%) хүн хамрагдсан бөгөөд хүйсийн хувьд 650 (74.3%) эрэгтэй, 225 (25.7 %) нь эмэгтэй, дундаж нас 44.3 ±11.9 жил байсан.

Хүснэгт 2. Тамхи татаж эхэлсэн нас, татсан жил, тамхины тоо

Үзүүлэлт	Нийт		Хүйс			
			Эрэгтэй		Эмэгтэй	
	Дундаж	С.Х	Дундаж	С.Х	Дундаж	С.Х
Тамхи татаж эхэлсэн нас	19.1	6.8	17.6	5.8	23.4	7.6
Өдөр бүр татаж эхэлсан нас	20.9	7.3	19.3	6.1	25.4	8.5
Өдөрт татдаг тамхины тоо	15.4	7.0	16.0	7.0	13.7	6.8

Судалгаанд оролцогчид дунджаар 19.1 ± 6.8 настайдаа тамхи татаж эхэлсэн бөгөөд хүйсээр нь харьцуулахад эрэгтэйчүүд эсрэг хүйсээс 5.8 жилийн өмнө буюу 17.6 насандаа тамхи татаж эхэлсэн байна. Тамхи татсан дундаж хугацаа 23.7 ± 11.8 жил, хүйсээр харьцуулж үзэхэд эрэгтэйчүүд эсрэг хүйсээс 2.8 жилийн их байна. Өдөрт татдаг тамхины тоо дунджаар 15.4 ± 7 ширхэг, эрэгтэйчүүд өдөрт дунджаар 16.0 ширхэг, эмэгтэйчүүд 13.7 ширхэг байсан.

Хүснэгт 3. Тамхинаас гарах оролдлого хийсэн тоо, тэвчсэн дундаж хугацаа

Үзүүлэлт	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	P утга
	Дундаж (с.х)	Дундаж (с.х)	Дундаж (с.х)	
Тамхинаас гарах оролдлого хийсэн тоо	2.4 (1.5)	2.3 (1.5)	2.5 (1.5)	0.274
Хамгийн сүүлд тамхинаас гарах оролдлого хийсэн жил	3.39 (5.88)	3.58 (6.11)	2.77 (5.06)	0.105
Тамхи татахгүй тэвчсэн хугацаа (сараар)	7.1 (18.5)	7.8 (20.4)	4.5 (9.6)	0.008

Судалгаанд оролцогчдын 638 (72.9%) нь тамхинаас гарах оролдлого хийж байсан байна. Судалгаанд оролцогчид дунджаар 2.4 ± 1.5 удаа тамхинаас гарах оролдлого хийж байсан ба эрэгтэйчүүд 2.3 ± 1.5 удаа, эмэгтэйчүүд 2.5 ± 1.5 удаа тамхинаас гарах оролдлого хийсэн байна. Тамхи татахгүй тэвчсэн дундаж хугацаа 7.1 ± 18.5 сар, эрэгтэйчүүд 7.8 ± 20.4 сар, эмэгтэйчүүд 4.5 ± 9.6 сар тамхи татахгүй тэвчсэн байна.

Хүснэгт 4. Эмчилгээ эхлүүлсэн болон бүрэн дуусгасан тохиолдлыг эмчилгээний бүлгээр харьцуулсан дүн

Үзүүлэлт	Эм	Наалт	Харьцангуй эрсдэл	Зөрүү	p value
	n=421	n=454	95% и.и.		
Тамхинаас гарсан: Огт татаагүй†					
14 хоног	212 (50.4)	204 (44.9)	1.121 (0.975 - 1.288)	5.5%	0.109
1 сар	245 (58.2)	218 (48)	1.212 (1.069 - 1.374)	10.2%	**0.003**
2 сар	192 (45.6)	176 (38.8)	1.176 (1.007 - 1.375)	6.8%	**0.041**
Тамхинаас гарсан: Огт татаагүй‡					
14 хоног	212 (63.2)	199 (54.4)	1.162 (1.026 - 1.316)	8.8%	**0.018**
1 сар	245 (73.4)	218 (59.6)	1.232 (1.107 - 1.37)	13.8%	**0.0001**
2 сар	192 (57.5)	176 (48.1)	1.195 (1.038 - 1.376)	9.4%	**0.013**
Тамхинаас гарсан: Огт татаагүй§					
2 сар	133 (56.8)	123 (49.4)	1.151 (0.973 - 1.361)	7.4%	**0.102**
Тамхинаас гарсан: Огт татаагүй¶					
2 сар	109 (62.3)	96 (50.8)	1.226 (1.023 - 1.47)	11.5%	**0.027**

† - Нийт тохиолдол 875 буюу ирээгүй хүмүүсийг урьдын адил тамхи татаж байна гэж тооцсон.

‡ - Нийт тохиолдол 700 буюу 1 дэх сард эмчилгээг бүрэн дуусгасан хүмүүст тооцсон.
§ - Нийт тохиолдол 483 буюу эмнэлзүйн удирдамжийн дагуу эмчилгээг бүрэн дуусгасан хүмүүст тооцсон.
¶ - Нийт тохиолдол 364 буюу эмнэлзүйн удирдамжийн дагуу эмчилгээг бүрэн дуусгасан болон цитизин эм, никотин оруулах наалтыг зааврын дагуу хэрэглэсэн хүмүүст тооцсон.

Эмчилгээ эхлүүлсэн 875 (100%) оролцогчдын дунд цитизин (табекс) эмийн бүлэгт 1 дэх сард 245 (58.2%) нь, 2 дахь сард 192 (45.6%) нь, никотин орлуулах орлуулах наалт эмчилгээний бүлэгт 1 дэх сард 218 (48%) нь, 2 дахь сард 176 (38.8%) нь тамхинаас гарсан байна. Цитизин эмийн эмчилгээний бүлгийг никотин орлуулах наалт эмчилгээний бүлэгтэй харьцуулахад 1 дэх сард 1.212 дахин их буюу 10.2 хувиар их (p=0.0003), хяналтын 2 дахь сард 1.176 дахин их буюу 6.8 хувиар илүү (p=0.041) үр дүнтэй байгаа нь статистик ач холбогдол бүхий ялгаатай байна.

Эмчилгээ бүрэн дуусгасан 700 (100%) оролцогчдын дунд цитизин (табекс) эмийн бүлэгт 1 дэх сард 245 (73.4%) нь, 2 дахь сард 192 (57.5%) нь, никотин орлуулах орлуулах наалт эмчилгээний бүлэгт 1 дэх сард 218 (59.6%) нь, 2 дахь сард 176 (48.1%) нь тамхинаас гарсан байна. Цитизин эмийн эмчилгээний бүлгийг никотин орлуулах наалт эмчилгээний бүлэгтэй харьцуулахад эмчилгээний 1 дэх сард 1.232 дахин их буюу 13.8 хувиар их (p=0.0001), хяналтын 2 дахь сард 1.195 дахин их буюу 9.4 хувиар илүү (p=0.013) үр дүнтэй байгаа нь статистик ач бүхий ялгаатай байна.

Хүснэгт 5. Эмчилгээ эхлүүлсэн болон бүрэн дуусгасан тохиолдлыг зөвлөгөөний бүлгээр харьцуулсан дүн

Үзүүлэлт	Зөвөлгөөтэй	Зөвөлгөөгүй	Харьцангуй эрсдэл	Зөрүү	P утга
	n=441	n=434	95% и.и.		
Тамхинаас гарсан: Огт татаагүй†					
14 хоног	228 (51.7)	188 (43.3)	1.194 (1.037 - 1.373)	8.4	**0.013**
1 сар	248 (56.2)	215 (49.5)	1.135 (1.001 - 1.287)	6.7	**0.047**
2 сар	196 (44.4)	172 (39.6)	1.121 (0.959 - 1.311)	4.8	0.149
	n=356	n=344	95% и.и.		
Тамхинаас гарсан: Огт татаагүй‡					
14 хоног	225 (63.2)	185 (53.8)	1.175 (1.036 - 1.333)	9.4	**0.011**
1 сар	248 (69.7)	215 (62.5)	1.115 (1.002 - 1.24)	7.2	**0.045**
2 сар	196 (55.1)	172 (50)	1.101 (0.956 - 1.268)	5.1	0.180
Тамхинаас гарсан: Огт татаагүй§					
2 сар	139 (54.7)	117 (51.1)	1.071 (0.905 - 1.268)	3.6	0.424
Тамхинаас гарсан: Огт татаагүй¶					
2 сар	115 (58.4)	90 (53.9)	1.083 (0.902 - 1.301)	4.5	0.390

† - Нийт тохиолдол 875 буюу ирээгүй хүмүүсийг урьдын адил тамхи татаж байна гэж тооцсон.
‡ - Нийт тохиолдлыг 700-аар буюу эмчилгээг бүрэн дуусгасан хүмүүст тооцсон.
§ - Нийт тохиолдол 483 буюу эмнэлзүйн удирдамжийн дагуу эмчилгээг бүрэн дуусгасан хүмүүст тооцсон
¶ - Нийт тохиолдол 364 буюу эмнэлзүйн удирдамжийн дагуу эмчилгээг бүрэн дуусгасан болон цитизийн эм, никотин оруулах наалтыг зааврын дагуу хэрэглэсэн хүмүүст тооцсон

Эмчилгээ эхлүүлсэн 875 (100%) оролцогчдын дунд зөвлөгөөтэй бүлэгт 1 дэх сард 248 (56.2%) нь, 2 дахь сард 196 (44.4%) нь, зөвлөгөөгүй бүлэгт 1 дэх сард 215 (49.5%) нь, 2 дахь сард 172 (39.6%) нь тамхинаас гарсан байна. Зөвлөгөөтэй бүлгийг зөвлөгөөгүй бүлэгтэй харьцуулахад эмчилгээний 1 дэх сард 1.135 дахин их буюу 6.7 хувиар их (p=0.047), хяналтын 2 дахь сард 1.121 дахин их буюу 4.8 хувиар илүү (p=0.149) үр дүнтэй байгаа ч статистик ач холбогдол бүхийн ялгаатай байна.


Эмчилгээг бүрэн дуусгасан 700 (100%) оролцогчдын дунд зөвлөгөөтэй бүлэгт 1 дэх сард 248 (69.7%) нь, 2 дахь сард 196 (55.1%) нь, зөвлөгөөгүй бүлэгт 1 дэх сард 215 (62.5%) нь, 2 дахь сард 172 (50%) нь тамхинаас гарсан байна. Зөвлөгөөтэй бүлгийг зөвлөгөөгүй бүлэгтэй харьцуулахад 1 дэх сард 1.115 дахин их буюу 7.2 хувиар их (p=0.045), хяналтын 2 дахь сард 1.101 дахин их буюу 5.1 хувиар илүү (p=0.180) үр дүнтэй байгаа ч статистик ач холбогдол бүхий ялгаатай байна.

Хүснэгт 6. Каплан-Мэйер аргаар дахих хугацааг зөвлөгөөний бүлэгт харьцуулсан дүн

Үзүүлэлт	Үнэлэгдсэн Медиан[a]	95% итгэх интервал		P утга
		Доод утга	Дээд утга	
Эм зөвлөгөөтэй	68	61.7	74.3	
Эм зөвлөгөөгүй	62	56.6	67.4	0.094
Наалт зөвлөгөөтэй	56	51.6	60.4	0.02
Наалт зөвлөгөөгүй	49	46	52.0	**0.001**
Нийт	**58**	**54.6**	**61.4**	

[a] - Хэрэв тамхи татаагүй бол хамгийн сүүлд хяналтанд хамрагдсан хугацаагаар хязгаарласан.

Тамхинаас гарсан өдрөөс дахин тамхи татах хүртэлх хугацааны медиан нь эм зөвлөгөөтэй бүлэгт 68 (95% CI, 61.7-74.3) хоног, эм зөвлөгөөгүй бүлэгт 62 (95% CI, 56.6-67.4), наалт зөвлөгөөтэй бүлэгт 56 (95% CI, 51.6-60.4), наалт зөвлөгөөгүй бүлэгт 49 (95% CI, 54.6–61.4) хоног байсан. Эм зөвлөгөөтэй бүлэгт наалт зөвлөгөөгүй бүлгээс 19 хоногоор их байгаа статистик ач холбогдол бүхий ялгаатай байна (p=0.001).



***Зураг 2.** Цитизин (табекс), никотин орлуулах эмчилгээний үр дүн хоногоор*

Аль ч хугацаанд наалт зөвлөгөөгүй бүлгийг наалт зөвлөгөөтэй бүлэгтэй харьцуулахад 1.156 (95% CI, 1.462 to 0.913) дахин их (p=0.228), эм зөвлөгөөгүй бүлэгтэй харьцуулахад 1.258 (95% CI, 1.605 to 0.987) дахин их (p=0.064)., эм зөвлөгөөтэй бүлэгтэй харьцуулахад 1.546 (95% CI, 1.992 to 0.198) дахин их үр дүнтэй буюу тамхинаас гаргаж байна (p=0.001).

Хэлцэмж

Natalie Walker, Colin Howe нарын 2014 онд 1310 хүнийг хамруулсан судалгаанд цитизин эмийн бүлэгт 2 дахь сард 246 (38) нь, никотин орлуулах наалт эмчилгээний бүлэгт эмчилгээний бүлэгт 206 (32) нь тамхинаас гарсан байна.[10] Дээрх эрдэмтдийн 2020 онд Шинэ Зеланд улсад хийгдсэн 1105 хүн хамруулсан судалгаанд цитизин эмийн эмчилгээний бүлэгт 2 дахь 59.3 хувь, вераниклин эмчилгээний бүлэгт 63.1 хувь нь тамхинаас гарсан байна. Дээрх судалгааны судалгааны үр дүнгээс харахад вераниклинтэй цитизин (табекс) эмийг харьцуулахад илүү үр дүнтэй байсан бөгөөд бидний судалгааны цитизин (табекс) эмийн эмчилгээний бүлэгттэй үр дүн ойролцоо байна.[15] Судлаач Pum Phusahat, Piyameth Dilokthornsakul, Watchara Boonsawat нарын 2018-2021 онд Тайланд улсад хийгдсэн 132 хүнийг хамруулсан цитизин (табекс) эмийн үр дүнг плацебо бүлэгтэй харьцуулж судалсан судалгаанд оролцогчдын дунд 3 дахь сард цитизин (табекс) эмийн эмчилгээний бүлэгт 26.8 хувь, плацебо бүлэгт 3 дахь сард 10.7% нь 6 дахь сард 009.3% нь тамхинаас гарсан байгаа нь бидний судалгааны үр дүнтэй харьцуулахад тамхинаас гарсан хувь бага байна.[17]

Бидний судалгаанд оролцогчдын дунд никотин орлуулах орлуулах наалт эмчилгээний бүлэгт хяналтын 2 дахь сард 176 (48.1%) нь тамхинаас гарсан бол судлаач Megan E. Schultz, Gaylen E Fronk нарын 2019-2020 онд АНУ-ын Вашингтон мужид 125 хүнийг хамруулсан стрессийн түвшинтэй холбож судалсан плацебо бүлэгтэй туршилт судалгаанд оролцогчдын дунд 3 дахь сард 43 (69.3%) нь плацебо бүлэгт 39 (62.9%) нь тамхинаас гарсан байна. Плацебо бүлэгтэй харьцуулахад никотин орлуулах наалт эмчилгээ 17.7 хувиар илүү үр дүнтэй байгаа нь бидний судалгааны үр дүнтэй ойролцоо байна.[21] Судлаач Josep M Ramon, Sergio Morchon нарын 2012-2013 Испани улсад 438 хүнийг хамруулсан никотин орлуулах наалт, вераниклин эмийг плацебо бүлэгтэй харьцуулсан санамсаргүй хяналтат туршилт судалгаанд вераниклин, никотин орлуулах наалт эмчилгээний бүлэгт 3 дахь сард 72 (42.2%) нь, плацебо бүлэг 3 дахь 69 (40.4%) нь, тамхинаас гарсан.

Дүгнэлт

1. Цитизин эмийн бүлэгт 192 (45.6%) нь, никотин орлуулах орлуулах наалт эмчилгээний бүлэгт 176 (38.8%) нь тамхинаас гарсан байна. Цитизин (табекс) эм никотин орлуулах наалт эмчилгээтэй харьцуулахад 1.186 дахин их буюу 6.8 хувиар илүү (p=0.041) үр дүнтэй байна.
2. Зөвлөгөөтэй бүлгийг зөвлөгөөгүй бүлэгтэй харьцуулахад 1.121 дахин их буюу 4.8 хувиар илүү (p=0.149) үр дүнтэй байна.

Талархал

Судалгаа хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн АНУ-ын Лома Линдагийн их сургууль, аргазүйн дэмжлэг үзүүлсэн АШУҮИС, НЭМС-ийн хамт олон “Тамхинаас гаргах эмийн эмчилгээ, зан үйлийг өөрчлөх интервенцийн төсөл”-ийн багийн хамт олонд талархсанаа илэрхийлье.

НОМЗҮЙ

1. *П.Энх-Учрал, Т.Ганцэцэг, Марелиз, Эндрью. Тамхинаас гарах хөтөлбөрийн үр дүн. Хүрэл тогоот – 2019:194-203*
2. *ЭМЯ, НЭМТ, ДЭМБ. Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын дөрөвдүгээр судалгаа – 2019. Улаанбаатар хот: Мөнхийн үсэг: 2019.*
3. *Эрүүл мэндийн хөгжлийн төв. Эрүүл мэндийн үзүүлэлт. Улаанбаатар 2021: 174-175*
4. *Walker N, Howe C, Glover M, McRobbie H, Barnes J, Nosa V, Parag V, Bassett B, Bullen C. Cytisine versus nicotine for smoking cessation. N Engl J Med. 2014 Dec 18;371(25):2353-62. doi: 10.1056/NEJMoa1407764.*

НҮҮР АМ СУДЛАЛЫН СУРГУУЛЬ
Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
1942

ЭРДМИЙН ЧУУЛГАН 65

НҮҮР АМ СУДЛАЛЫН САЛБАР ХУРАЛДААН

